



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/ЗМ

Булган сум

**“Дохионы хэлний хэлмэрч бэлтгэх сургалт”-ыг  
зохион байгуулах тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, 42.1.4 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн нийгмийн харилцаанд оролцоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой “Дохионы хэлний сургалт”-ыг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 90 хоногийн хугацаанд зохион байгуулж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

2.Сургалтад хамрагдах мэргэжилтэн, албан хаагчдын нэрсийг болон шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Сургалт зохион байгуулахад шаардагдах хөрөнгө болох 8,100,000 (найман сая нэг зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2026 оны  
ОН дүгээр сарын 29-ныгний өдрийн  
А/ЗН дугаар захирамжийн хавсралт

**“ДОХИОНЫ ХЭЛНИЙ СУРГАЛТ” ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ  
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

д/д	Агентлаг, байгууллагын нэр	Албан хаагчийн нэр	Нэг сарын төлбөр (төгрөг)	Сургалт зохион байгуулах сар	Нийт төлбөр (төгрөг)
1	2	3	4	5	6
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	О.Ундрах	300,000	3	900,000
2	Нийгмийн даатгалын газар	Г.Энхтүвшин	300,000	3	900,000
3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	У.Мөнгөнтуяа	300,000	3	900,000
4	Татварын газар	Ж.Мөнхзул	300,000	3	900,000
5	Булган сумын Засаг даргын тамгын газар	Э.Ганчимэг	300,000	3	900,000
6	Боловсролын газар	Д.Дэжидбаа	300,000	3	900,000
7	Хүнс, хөдөө, аж ахуйн газар	Б.Шүрэнцэцэг	300,000	3	900,000
8	Улсын бүртгэлийн хэлтэс	Л.Байгалмаа	300,000	3	900,000
9	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Г.Отгонцэцэг	300,000	3	900,000
<b>Нийт төлбөр</b>					<b>8,100,000</b>

--o00o--